
МЭДЭЭ · 2025 оны 5-р сарын 5

ТӨСВИЙН ХӨРӨНГИЙГ ЗОРИУЛАЛТЫН БУСААР ЗАРЦУУЛСАН ХЭРГИЙГ ШҮҮХЭД ШИЛЖҮҮЛЛЭЭ



Прокурорын байгууллага 2025 оны 4 дүгээр сарын 28-наас 5 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл хугацаанд 150 хэрэгт яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүллээ.

Яллах дүгнэлт үйлдсэн хэргийг тодруулбал, Эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 46, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 37, Өмчлөх эрхийн эсрэг 35, Авлигын 7, Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг 7, Хүрээлэн байгаа орчны эсрэг 6, Хүний амьд явах эрхийн эсрэг 5, Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг 4, Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг 2, Эдийн засгийн 1 хэрэг байна.



Шүүхэд шилжүүлсэн зарим хэргээс дурдвал:

Нийслэлийн прокурорын газраас Нийслэлийн хот байгуулалтын асуудал хариуцсан нийтийн албан тушаалтнаар ажиллаж байсан О.М нар нь нэр бүхий иргэний эзэмшлийн газрын нэгж талбарыг 455 мкв-аар нэмэгдүүлэх зорилгоор эрх мэдэл албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, мэргэжлийн зөвлөлийн гишүүдэд хууль бусаар нөлөөлж, бусдад давуу байдал бий болгосон хэрэгт Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 /Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхэд,

Цаг уур орчны шинжилгээний газрын ажилтан С.Э нь тендер сонгон шалгаруулалтад нэр бүхий аж ахуйн нэгж нь зээлийн мэдээллийн сангийн лавлагаа ирүүлээгүй байхад ирүүлсэн мэтээр танилцуулж, улмаар тухайн аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, зээлийн мэдээллийн сангийн лавлагааг нөхөн авч тендерийн баримт бичигт хавсаргаж бусдад давуу байдал бий болгосон хэрэгт Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 /Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхэд,

"Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалтын үйлдвэр" төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газарт нийтийн албан тушаалтнаар ажиллаж байсан З.Б нар нь тус газрын үйл ажиллагааг сайжруулах төслийн хүрээнд техник технологийг шинэчилж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд зарцуулах ёстой төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсны улмаас төсөвт 61.8 сая төгрөгийн хохирол учруулсан хэрэгт Эрүүгийн хуулийн 22.8 дугаар зүйлийн 1 /Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхэд,

Нийслэлийн нэр бүхий дүүрэгт барьсан 240 айлын орон сууцны зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гаргуулж, өөртөө давуу байдал бий болгох зорилгоор бусдад хахууль өгсөн Э.М-д холбогдох хэрэгт Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 1 /Хахууль өгөх/-д Дүүргийн эрүү, иргэний хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхэд,

Иргэн С.Б нь их хэмжээний татварын өрийг нуух, татвар төлөхөөс зайлсхийх зорилгоор нийт 1.3 тэрбум төгрөгийн бараа үйлчилгээг худалдан авсан мэтээр зориуд худал тодорхойлон, төсөвт төлөх нэмэгдсэн өртгийн албан татварын дүнг 134 сая төгрөгөөр бууруулан татвар төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн хэрэгт Эрүүгийн хуулийн 18.3 дугаар зүйлийн 1 /Татвар төлөхөөс зайлсхийх/-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүхэд тус тус шилжүүллээ.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/751